

ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 4-т “Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой, Тавантолгой, Цагаан суварга, Асгатын ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон бөгөөд мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын 1-д зааснаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байршилтай Тавантолгойн чулуун нүүрсний ордод Тавантолгой ХК, Энержиресурс ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулахаар заасан.

Гэвч стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайд нүүрс олборлох үйл ажиллагаа болон Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх нь эргэлзээ үүсгэсэн мэдээлэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байна.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн чулууны нүүрсний бүлэг ордод хамаарах ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах шаардлага үүсээд байна.

Иймд Тавантолгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх, Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан агуулга болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүтэц бүхий 5 заалттай болно.

Тогтоолын төслийн 1 дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах үндэслэл болон түр хорооноос хэрэгжүүлэх тусгай шалгалтын сэдвийг, 2 дахь заалтаар тусгай шалгалтын хүрээ хязгаарыг, 3 дахь заалтаар хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг, 4 дэх заалтаар хянан шалгах түр хорооны ажиллах болон үр дүн буюу санал, дүгнэлтийг тайлагнах хугацааг, 5 дахь заалтаар тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох зохицуулалтыг тусгасан болно.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 34, 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг ханган боловсруулсан бөгөөд хуульд заасны дагуу Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордтой холбогдуулж олон нийтийн мэдэх эрхийг хангаж, иргэд Тавантолгойн бүлэг ордыг хамрах тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалт, эдийн засгийн үр өгөөж, нөөц, байгуулсан оффтейк гэрээнүүдийн хэрэгжилттэй холбогдуулж бодит мэдээлэлтэй болно.

Мөн Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордтой холбоотой мэдээлэл, дүн шинжилгээг нэгтгэх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх” зарчим хангагдах нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22-т заасны дагуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахад хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах болон төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийхийг шаардахгүй бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.